



“ТӨРИЙН БАНК” ХХК-Д

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр,
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41

2019.02.18 № 1/168
танай _____-ны № _____-т

Тендер шалгаруулалтын тухай

Танай банкаас зарласан “Даатгалын үйлчилгээ үзүүлэх” тухай ТБ/201808431 дугаартай тендерийн баримт бичигт холбогдох гомдлыг “Хаан даатгал” ХХК-аас тус газарт ирүүлсний дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хянаж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.4-т заасны дагуу гомдлыг хянан хэлэлцэж шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг тендер шалгаруулалттай холбогдуулан гаргасан захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг, тендер шалгаруулалтын материал авах, нээлт хийх үйл ажиллагааг түр түдгэлзүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Уг тендер шалгаруулалттай холбогдох баримт материал, тайлбарыг 2019 оны 02 дугаар сарын 20-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Холбоо барих утас: 264165,

ДАРГА



Б.ЛХАГВА